



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 123

Улаанбаатар хот

Дуудлагын худалдаа зохион байгуулах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3 нэрийн нийт 109,310,339.98 (нэг зуун есөн сая гурван зуун арван мянга гурван зуун гучин есөн төгрөг өрэн найман мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Худалсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001443

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 4 дугаар сарын 21ний өдрийн  
6/3 дугаарт тогтооны хавсралт

"ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СУЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН  
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДАГ ААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСАЛТ

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон огноо	Баласнын үнэ, хуимтлагдсан элэгдэл	Дуудлагаар худалдах доод үнэ (төгрөг)	Байршил
1	УАЗ-469, 73-33 ОРО, 40599700	2004/2004	12,781,733.65	1,500,000.00	ХБС
2	Ланд крүйзер-100, 56-05УБК, JTEHT05J312005724	2001/2008	57,286,297.65	6,200,000.00	ЗӨБС
3	Тойота Ланд-75, 57-55 УББ	1998/1998	39,242,308.68	4,000,000.00	УБС
			<b>109,310,339.98</b>	<b>11,700,000.00</b>	-
	<b>Нийт дун</b>		(нэг зуун есөн сая түрван зуун арван мянга түрван зуун гучин түрөг ерэн найман мөнгө)	(арван нэгэн сая доллоон зуун мянган)	-